

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖИЙН 2021 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН БИЕЛЭЛТ**

2021 оны 09 дүгээр сарын 30

Багануур дүүрэг

| № | Ирсэн огноо | Батлагдсан огноо | Дугаар | Биелэлт |
|---|-------------|------------------|--------|--|
| 1 | 2021.06.18 | 2021.06.16 | A/477 | <p>Засгийн газрын 2021 оны 118 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны A/477 дугаар захирамжийн хүрээнд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулж дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. - Ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр агааржуулалтыг хийн, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээг зохион байгуулж байна. - Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна. - "Ковид 19 эрсдэл систем"-ийг бүх албан хаагчдад гар утсандаа суулган ашиглаж байна. - Байгууллагын бүх албан хаагчид дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсан. <p>Түрээслүүлэгч байгууллагад коронавирусын халдварын батлагдсан тохиолдол ихэсч, манай байгууллагын зарим ажилчдаас шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан ажилчдыг шинжилгээнд хамруулж, ажлын байранд мэргэжлийн байгууллагаар ариутгалыг гүйцэтгүүлэн, нийслэлийн Онцгой комиссын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 593 дугаартай албан бичгээр өгсөн "Ковид-19 халдвараас сэргийлэх, батлагдсан тохиолдол бүртгэгдсэн үед авах хариу арга хэмжээний түр зааварчилгаа"-ны 2.3 дахь заалтын дагуу бүх ажилчдыг цахимаар ажиллах нөхцөлөөр ханган байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулж, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан түр зааварчилгааг хэрэгжүүлж ажилласан.</p> |
| 2 | 2021.06.22 | 2021.06.18 | A/483 | <ul style="list-style-type: none"> - Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн зураг төсөл дуусч паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил эхлэх гэж байгаатай холбогдуулан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлуулах, Хөгжлийн стратеги төлөвлөлтөөр эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалтуудыг хугацаанд нь шийдвэрлүүлэх, байгууллагын үндсэн чиглэлийг өөрчлөхгүй байх |

| | | | | |
|--|--|--|--|---|
| | | | | саналуудыг НШУУИГ-ын даргад 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 135 дугаартай албан бичгээр хургуулсан. |
|--|--|--|--|---|

ХЯНАСАН:

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э. ЭНХЗАЯА

